



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот


“Эрчим инженеринг” ХХК-ийн нийтэд санал
болгон гаргасан өрийн хэрэгслийг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим инженеринг” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 50,000 /тавин мянга/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Ш. Лхагва/-нд тус тус үүрэг болгосугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГӨГЧ,
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД